

Аймгийн
АН-ын хорооны тэргүүлэгчдийн
хурлаар хэлэлцэж батлав.
2022.оны 4-р сарын 8-ны өдөр

БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ӨЛЗИЙТ СУМЫН НӨХӨН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн уриа: Хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт

Нэг. Хүртээмжтэй эдийн засаг, өсөлтийг хангах бодлого.

1.1. Сумын ДНБ-ний үйлдвэрлэлийг жил бүр өсгөж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг “ Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”ын баримт бичигт заасан хэмжээнд хүргэх.

1.2. Сумандаа ахуйн үйлчилгээ, гар урлал, гутал, оёдлын цех, үйлдвэрийг байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

1.3. “Баянхонгорт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг сумандаа байгуулж орон нутгийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалтын болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

1.5. Төмс хүнсний ногоогоор нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, энэ үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх

Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө

2.1. Боловсрол

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ. Багшийн хангамжийг сайжруулна.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлнэ.

2.1.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд ААН, байгууллагуудыг дэмжинэ.

2.1.4. Сургууль цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагын чадавхийг сайжруулна.

2.1.5. Анги дэвших төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 60-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.



000001
[Handwritten signatures]

2.1.6. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтад малчдын хүүхдийг хамруулна.

2.1.7. Багш солилцох хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна Англи хэлний мэргэжилтэн багш нарыг Энхтайвны корпустай хамтарч урьж ажиллуулна.

2.2.Эрүүл мэнд

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадвар сайтай хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэх

2.2.3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, сургалтанд хамруулах,ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр эн тэргүүнд хангана.

2.2.5.Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.6.Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,нийгмийн хамгаалал

2.3.1. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төв суурингийн өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.3. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.


2.3.4. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж,тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвхи санаачилга, боломжийг дэмжиж , хөгжүүлнэ.

2.3.5. Залуу гэр бүлийг эхний ээлжинд ажлын байр, хөнгөлөлттэй тохилог сууцанд хамруулах, оюутан залуусыг дэмжих бодлого баримтална.

2.3.6. Зам дагасан үйлдвэрлэл үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

Гурав. Хөдөө аж ахуй,Байгаль орчин

3.1. Мал аж ахуй



6417
10406

3.1.1. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.

3.1.2. Сүргийн бүтэц, эргэлтийг сайжруулж, МAA-гаас ашиглах сүү, цагаан идээ, мах, ноос ноолууран ашиг шимийг бүрэн ашиглаж, зах зээлийн үнийн эрсдлээс хамгаалж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.3. Сумын хонин сүрэгт Барга, Баянцагаан үүлдрийг сайжруулагчаар ашиглаж, амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

3.1.4. Малын эрүүл мэндийг хамгаалахад анхаарч, малын эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, мал эрүүлжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.

3.2. Газар тариалан:

3.2.1. Тохиромжтой бүсүүдэд төмс, хүнсний ногоо, малын тэжээл, хадлан бэлтгэх ашиглах арга хэмжээ авна.

3.2.2. Тохиромжтой газруудад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх.

3.2.3. Сумын Бор балгас, Хөшөөт, Бумбатын услалтын системүүдийг сэргээн засварлаж, бүрэн ашиглана.

3.2.4. Эрдэнийн хөндий, Байн хөндийд хадлан, тэжээлийн ургамал тариалахыг бодлогоор дэмжинэ.

3.3. Тогтвортой байгаль орчин

3.3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.2. Хөдөөгийн эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.3. Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарна.

3.3.4. Гол горхи, булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах, модлог ургамлуудыг тариалах, ногоон массыг нэмэгдүүлэх. Энэ санаачилгыг дэмжих.

3.3.5. Нүүдлийн МAA-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.


Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал

4.1. Сайн засаглал

4.1.1. Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2. Төрийн байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан, мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог дагаж мөрдөнө.

4.1.3. Иргэдээс төрийн алба, албан тушаалтантай холбоотой авлига, хээл хахууль, ашиг сонирхолын зөрчлийн талаар гаргасан мэдээллийг хүлээн авах


000003



143544
000742

цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

4.2.Төсөв санхүү

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2.Төсвийн зардлыг ач холбогдолоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, сумын төсвийн чадавхийг нэмэгдүүлнэ.

4.3. Сум, багийн хөгжил.

4.3.1. Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод,хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулна.

4.3.2. Багийн төвүүдийг шинэчлэх төслийг сэргээж, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.4. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах

4.4.1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулж “Архигүй Өлзийтчүүд ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй сум ” болохыг зорино.

БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ

 
000004

